



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/98

Мандалговь

“Тэлмэн нетворк” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн А/62 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Тэлмэн нетворк” ХХК-тай 33,886,600 (гучин гурван сая найман зуун наян зургаан мянга зургаан зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг, төсвийн дагуу “Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж худалдан авах” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тэлмэн нетворк” ХХК-ийн захирал (Э.Сүхбат)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа), Аймгийн Музейн дарга (Т.Бямбажав), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

48206040